

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны . . . сарын . . . - ны өдрийн хуралдааны  
. . . дугаар тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар,  
Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хоорондын  
хэлэлцээр”-ийн төслийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах  
Словени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд,  
уг хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд олгох тухай  
Ерөнхий сайдын захирамжийг ажлын шугамаар гаргахаар тогтов” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

Дугаар ...

Гарын үсэг зурах эрх олгох тухай

"Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-г гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд олгосугай.

ГАРЫН ҮСЭГ

## ТАНИЛЦУУЛГА

“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар,  
Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар  
хоорондын хэлэлцээр”-ийн төслийн тухай

Зам, тээврийн яамны зүгээс Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд агаарын тээврийн либералчлалыг дэмжиж аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, улс орнуудтай, ялангуяа Европын Холбооны Улсуудтай агаарын харилцаа тогтоох, нислэгийн сүлжээг өргөжүүлэх асуудлыг 2021 оноос эрчимжүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд 2023 онд Грек улстай, 2024 онд Унгар, ИБУИНХУ, Латви зэрэг улстай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулж, Словени улстай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохироод байна.

“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл нь Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцод нийцүүлэн, хоёр орны нутаг дэвсгэрийн хооронд болон хилийн чанадад агаарын харилцаа тогтоох зохицуулалтыг тохирсон, олон улсын нийтлэг жишгээр үйлдсэн төсөл юм.

Хэлэлцээрийн төсөл нь нийт 26 зүйлтэй бөгөөд тээвэрлэлтийн эрх олгох, томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, хууль тогтоомжийг хэрэглэх, шууд дамжин өнгөрөх нислэг, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, ашиглагчдад ногдуулах хураамж, гаалийн татвар болон бусад хураамжаас чөлөөлөх болон багтаамжийн зохицуулалт зэргийг тодорхойлсон. Мөн тариф, орлого гуйвуулах, арилжааны үйл ажиллагаа, аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт, статистик мэдээлэл, зөвлөгөөн, маргаан шийдвэрлэх, нэмэлт өөрчлөлт зэрэг зарчмын зохицуулалтуудыг тусгасан.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хооронд Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулснаар хоёр улсын хооронд шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалт бүрдэж, Төв Европт оршин сууж буй Монгол Улсын иргэд, бизнес аялагчид, жуулчид бага хугацаанд, тав тухтай зорчих боломжийг бүрдүүлнэ.

Түүнчлэн цаашид Европын орнууд руу шинээр нээх нислэгийн завсрын цэг болгон ашиглах боломжтой бөгөөд агаарын харилцааг өргөжүүлэх, олон улсын тээвэр, логикийн сүлжээнд холбогдох, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэх, Монгол, Словени хоёр улсын харилцаа, худалдаа-эдийн засаг, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал дэмжлэг болно гэж үзэж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

**АГААРЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ**  
**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**  
**БОЛОН**  
**БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**  
**ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар нь, (цаашид “Хэлэлцэн тохиролцогч Талууд” гэж нэрлэх)

Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр гарын үсэг зурж нээлттэй болсон Олон улсын Иргэний нисэхийн тухай Конвенцод оролцогч Хэлэлцэн тохиролцогч Талууд болохын хувьд,

Тус тусын нутаг дэвсгэрийнхээ хооронд болон тэдгээрийн хилийн чанадад агаарын харилцааг хөгжүүлэх зорилгоор Хэлэлцээр байгуулахыг эрмэлзэн;

Олон улсын агаарын тээврийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэн,

Дараах зүйлсийг тохиров:

## Гарчиг

### Хэлэлцээрийн оршил

1 дүгээр зүйл

2 дугаар зүйл

3 дугаар зүйл

4 дүгээр зүйл

5 дугаар зүйл

5А дугаар зүйл

6 дугаар зүйл

7 дугаар зүйл

8 дугаар зүйл

9 дүгээр зүйл

10 дугаар зүйл

11 дүгээр зүйл

12 дугаар зүйл

13 дугаар зүйл

14 дүгээр зүйл

15 дугаар зүйл

16 дугаар зүйл

17 дугаар зүйл

18 дугаар зүйл

19 дүгээр зүйл

20 дугаар зүйл

21 дүгээр зүйл

22 дугаар зүйл

23 дугаар зүйл

24 дүгээр зүйл

25 дугаар зүйл

26 дугаар зүйл

### Хавсралт

Тодорхойлолт

Тээвэрлэлтийн эрх олгох

Томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах,

түдгэлзүүлэх, хязгаарлах

Хууль тогтоомжийг хэрэглэх

Шударга өрсөлдөөн

Шууд дамжин өнгөрөх

Үнэмлэх, гэрчилгээг хүлээн зөвшөөрөх

Нисэхийн аюулгүй ажиллагаа

Нисэхийн аюулгүй байдал

Ашиглалтын хураамж

Гаалийн татвар болон бусад хураамжууд

Багтаамж

Тариф

Орлого гуйвуулах

Арилжааны үйл ажиллагаа

Аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт

Цагийн хуваарь

Статистик мэдээлэл

Зөвлөгөөн

Маргаан шийдвэрлэх

Нэмэлт өөрчлөлт

Олон төрөлт тээврийн үйлчилгээ

Олон талт хэлэлцээрүүд

Олон улсын иргэний нисэхийн байгууллагад

бүртгүүлэх

Хэлэлцээр цуцлах

Хүчин төгөлдөр болох

## 1 ДҮГЭЭР ЗҮЙЛ Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцүүлэн, агуулгын хувьд өөрөөр заагаагүй бол:

(a) “Конвенц” гэж 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Чикаго хотноо байгуулсан Олон улсын иргэний нисэхийн Конвенц, энэхүү Конвенцын (90) дүгээр зүйлийн дагуу батлагдсан аливаа Хавсралт болон Конвенцын (90) болон (94) дүгээр зүйлийн дагуу Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулсан Хавсралт болон Конвенц, тэдгээрийг Хэлэлцэн тохиролцогч Талууд баталсан эсхүл соёрхон баталсан нэмэлт өөрчлөлтийг хэлнэ;

(b) “Хэлэлцээр” гэж энэхүү Хэлэлцээр, түүний Хавсралт болон тэдгээрт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хэлнэ;

(c) “нисэхийн удирдах байгууллага” гэж Монгол Улсын хувьд Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Бүгд Найрамдах Словени Улсын хувьд Дэд бүтцийн яам эсхүл аль ч тохиолдолд энд дурдсан нисэхийн удирдах байгууллагуудын хэрэгжүүлж буй чиг үүргийг гүйцэтгэх эрх хуулиар олгогдсон аливаа удирдах байгууллага эсхүл тэдгээрийн залгамжлагчийг хэлнэ;

(d) “агаарын тээвэр” гэж зорчигч, тээш, ачаа болон шууданг хамтад нь эсхүл тусад нь, хөлсөөр эсхүл төлбөртэй тээвэрлэх агаарын тээврийг хэлнэ;

(e) “агаарын тээврийн үйлчилгээ”, “олон улсын агаарын тээврийн үйлчилгээ”, “агаарын тээвэрлэгч” болон “арилжааны бус зорилготой буулт” гэсэн тодорхойлолтууд нь Конвенцын (96) дугаар зүйлд заасан утгыг хэлнэ;

(f) “нутаг дэвсгэр” гэж Улсын хувьд Конвенцын (2) дугаар зүйлд заасан утгыг илэрхийлнэ;

(g) “тохиролцсон үйлчилгээ” гэж зорчигч, тээш, ачааг дангаар нь эсхүл хамтад нь тохиролцсон багтаамжийн зохицуулалтын дагуу энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тусгасан маршрутаар тээвэрлэх олон улсын хуваарьт агаарын тээврийн үйлчилгээг хэлнэ;

(h) “багтаамж” гэж:

1. Агаарын хөлгийн хувьд маршрутын дагуу тухайн агаарын хөлгийн боломжит ачаалал,
2. Тохиролцсон үйлчилгээний хувьд ийм үйлчилгээнд ашиглаж буй агаарын хөлгийн тээвэрлэх боломжит суудлын тоо эсхүл тээвэрлэх боломжит ачааны тонн хэмжээг тухайн маршрутад эсхүл маршрутын хэсэгт энэ агаарын хөлгийн үйлдсэн нислэгийн давтамжаар үржүүлсэн тоог хэлнэ;

(i) “томилогдсон агаарын тээвэрлэгч” гэж энэхүү Хэлэлцээрийн (3) дугаар зүйлд нийцүүлэн томилогдсон болон тохиролцсон үйлчилгээ үзүүлэх эрх авсан агаарын тээвэрлэгчийг хэлнэ;

(j) “тариф” гэж зорчигч, тээш, болон ачаа (шуудан тээвэрлэх нөхцөлийг оруулахгүй) тээвэрлэх үнэ эсхүл тээвэрлэлтэд төлөх хураамж болон эдгээр үнэ, хураамжийг хэрэглэх нөхцөлүүд, тээвэрлэлт хийхэд агентын үзүүлсэн үйлчилгээний

төлбөр, агаарын тээвэрлэгчийн ийм тээвэрлэлтэд үзүүлсэн нэмэлт үйлчилгээний нөхцөлүүд, тээвэрлэлтээс үүсэх аливаа нэмэлт үнэлэмжийн давуу байдлыг харгалзан тогтоох тээвэрлэлтийн үнийг хэлнэ;

(k) “ашиглалтын хураамж” гэж нисэх буудал, түүний тоног төхөөрөмж эсхүл агаарын навигацийн тоног төхөөрөмж, эсхүл нисэхийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж ашиглуулсан эсхүл үйлчилгээ үзүүлсэн болон агаарын хөлөг, нисгэх баг, зорчигчид, тээш, ачаанд хамаарах үйлчилгээ үзүүлсний төлөө агаарын тээвэрлэгч эрх бүхий байгууллагаас ногдуулж буй эсхүл ногдуулахыг зөвшөөрсөн хураамжуудыг хэлнэ;

(l) “Олон төрөлт тээврийн үйлчилгээ” гэж агаарын хөлөг болон нэг эсхүл олон төрлийн тээврийн хэрэгслээр зорчигч, тээш, ачаа болон шууданг тусад нь эсхүл хослуулан, хөлсний болон түрээсийн хэлбэрээр тээвэрлэхийг хэлнэ;

(m) “Европын Холбооны гишүүн улс” гэж Европын Холбооны Гэрээнд оролцогч тал болох улсыг хэлнэ;

(n) Энэхүү Хэлэлцээрт “Европын Холбооны Гэрээ”-ний тухай эшлэлүүдийг Европын Холбооны тухай Гэрээ болон Европын Холбооны үйл ажиллагааны тухай Гэрээтэй хамаатай гэж ойлгоно;

(o) Европын Холбооны гишүүн улс дахь иргэдийн тухай эшлэлүүдийг Европын Холбооны гишүүн улсын иргэд гэж ойлгоно;

(p) Европын Холбооны гишүүн улсын агаарын тээвэрлэгч эсхүл агаарын тээврийн компанийн тухай эшлэлүүдийг тухайн гишүүн улсаас томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл агаарын тээврийн компанийг гэж ойлгоно.

## **2 ДУГААР ЗҮЙЛ**

### **Тээвэрлэлтийн эрх олгох**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа олон улсын агаарын тээврийн үйлчилгээний дараах эрхийг олгоно.
  - (a) Нутаг дэвсгэрт нь буулгүйгээр шууд дамжин нисэж өнгөрөх ;
  - (b) Нутаг дэвсгэрт нь арилжааны бус зорилготой буулт хийх.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа Хэлэлцээрийн Хавсралтад орсон Маршрутын хуваариар тогтоосон маршрутад олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх эрх олгоно. Тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээ үзүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч Тал бүрээс томилогдсон агаарын тээвэрлэгч энэ зүйлийн (1), (2)-т заасан эрхүүдээс гадна олон улсын зорчигч, тээш, ачаа, шууданг дангаар эсхүл хамтад нь агаарын хөлгийн бүхээгт авах, буулгах зорилгоор энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад заасан маршрут дахь цэгүүдэд зогсолт хийх эрхтэй.
3. Энэ зүйлийн (2) дахь заалт нь Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт (каботаж) мөн гуравдагч улсын нутаг дэвсгэр дэх цэгүүд рүү (Агаарын тээврийн 5 дугаар эрхтэйгээр) зорчигч, ачаа, шууданг хөлсөөр эсхүл урамшууллаар тохирсон нэг цэгээс нөгөө цэг рүү тээвэрлэх эрх олгосон гэж ойлгохгүй.

Агаарын тээврийн 5 дугаар эрхийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд хоорондын тусгай хэлэлцээрийн үндсэн дээр олгоно.

4. Зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн асуудал, эсхүл онцгой буюу ердийн бус нөхцөл байдлын улмаас Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч тухайн үйлчилгээг тогтоосон маршрутаар гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал тухайн үйл ажиллагааг нэн даруй үргэлжлүүлэхийн тулд маршрутын түр зуурын зохих зохицуулалт хийх талаар хүчин чармайлт гаргана.

### **3 ДУГААР ЗҮЙЛ**

#### **Томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр тохиролцсон үйлчилгээг явуулахаар олон агаарын тээвэрлэгчийг дипломат шугамаар томилох эрхтэй бөгөөд томилгоог цуцлах эсхүл түдгэлзүүлэх эрхтэй.
2. Ийм томилгооны бичиг болон нислэг үйлдэх эрх бүхий томилогдсон агаарын тээвэрлэгчээс зохих журмын дагуу бүрдүүлсэн техникийн зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авмагц дараах нөхцөлийг хангасан тохиолдолд нислэг үйлдэх зөвшөөрлийг боломжит хамгийн бага хугацаанд, хойшлуулалгүй олгоно. Үүнд:
  - (a) Бүгд Найрамдах Словени Улсын талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн хувьд:
    - (i) Европын Холбооны Гэрээний дагуу Словенийн нутаг дэвсгэрт байгуулагдсан, мөн Европын Холбооны хууль тогтоомжийн дагуу Үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй гэрчилгээтэй,
    - (ii) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт олгох үүрэгтэй Европын Холбооны гишүүн улсаас агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны үр дүнтэй зохицуулалтын хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулах бөгөөд холбогдох иргэний нисэхийн удирдах байгууллагыг томилгоо дээр тодорхой заасан, болон
    - (iii) Агаарын тээвэрлэгчийг шууд эсхүл олонхын өмчлөлөөр өмчилдөг, мөн Европын Холбооны гишүүн улсууд эсхүл Европын чөлөөт худалдааны холбоо болон/эсхүл эдгээр улсуудын иргэд үр дүнтэй хяналт тавьдаг,
  - (b) Монгол Улсын талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн хувьд:
    - (i) Томилогдсон агаарын тээвэрлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулагдсан болон үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг,
    - (ii) Томилогдсон агаарын тээвэрлэгчийн үр дүнтэй зохицуулалтын хяналтыг Монгол Улсаас хэрэгжүүлж, баталгаажуулдаг;
  - (c) Тухайн агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Тал нь 8 дугаар зүйл (Нисэхийн аюулгүй ажиллагаа), болон 9 дүгээр зүйл (Нисэхийн аюулгүй байдал) дэх заалтуудыг хангасан байна;



- (d) Тухайн агаарын тээвэрлэгч нь томилгоог хүлээн авагч Хэлэлцэн тохиролцогч Талын олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжид заасан бусад нөхцөлүүдэд нийцсэн байх;
3. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал өөрийн томилсон агаарын тээвэрлэгчийг энэ зүйлийн (1), (2) дахь заалтуудын дагуу өөр агаарын тээвэрлэгчээр сольж томилох эрхтэй. Шинээр томилогдсон агаарын тээвэрлэгч нь өмнөх агаарын тээвэрлэгчтэй ижил эрх, үүрэгтэй байна.

#### **4 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

##### **Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, хязгаарлах**

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгч олгосон үйл ажиллагааны эсхүл техникийн зөвшөөрлийг дараах тохиолдолд түр хугацаагаар эсхүл хүчингүй болгож, цуцалж, хязгаарлаж болно. Үүнд:

- (a) Бүгд Найрамдах Словени Улсын талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн хувьд:
- (i) Европын Холбооны Гэрээний дагуу Бүгд Найрамдах Словени Улсын нутаг дэвсгэрт байгуулагдаагүй эсхүл Европын Холбооны хууль тогтоомжийн дагуу Үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй гэрчилгээгүй; эсхүл
  - (ii) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт олгох үүрэгтэй Европын Холбооны гишүүн улсаас агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны үр дүнтэй зохицуулалтын хяналтыг хэрэгжүүлдэггүй эсхүл баталгаажуулдаггүй, эсхүл холбогдох иргэний нисэхийн удирдах байгууллагыг томилгоо дээр тодорхой заагаагүй; эсхүл
  - (iii) Агаарын тээвэрлэгчийг шууд эсхүл олонхын өмчлөлөөр өмчилдэггүй, болон/эсхүл Европын Холбооны гишүүн улсууд эсхүл Европын чөлөөт худалдааны холбоо болон/эсхүл эдгээр улсуудын иргэд үр дүнтэй хяналт тавьдаггүй;
- (b) Монгол Улсын талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн хувьд:
- (i) Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулагдаагүй эсхүл Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрчилгээжээгүй; эсхүл
  - (ii) Монгол Улсын эрх бүхий байгууллагаас агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны үр дүнтэй зохицуулалтын хяналтыг хэрэгжүүлдэггүй эсхүл баталгаажуулдаггүй; эсхүл
  - (iii) Агаарын тээвэрлэгчийг шууд эсхүл олонхын өмчлөлөөр өмчилдэггүй, эсхүл Монгол Улс болон/эсхүл тухайн улсын иргэд үр дүнтэй хяналт тавьдаггүй.

#### **5 ДУГААР ЗҮЙЛ**

##### **Хууль тогтоомжийг хэрэглэх**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлж буй агаарын хөлгийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээсээ гаргах, эсхүл нутаг дэвсгэрт нь байгаа тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа, навигацитай

холбогдох хууль тогтоомжийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгч баримтална.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын нутаг дэвсгэр руу зорчигч, нисгэх баг, тээш болон шуудан оролцуулсан ачааг оруулах, нутаг дэвсгэрт нь байлгах, дамжин өнгөрөх эсхүл нутаг дэвсгэрээс нь гарахад мөрдөх Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, журмууд, түүнчлэн нутаг дэвсгэрт орох, гарах, иргэдийн шилжих хөдөлгөөн, паспорт, гааль, валюттай хамаарах хууль, тогтоомж, журмууд, хорио цээр, эрүүл мэнд, мал эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээнүүдийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэж ирсэн зорчигч, тээш, нисгэх баг, тээш болон шуудан оролцуулсан ачааг Хэлэлцэн тохиролцогч энэ Талын нутаг дэвсгэрт орох, байх, нутаг дэвсгэрээс гарахад хэрэглэнэ.
3. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал гааль, иргэдийн шилжих хөдөлгөөн, хорио цээрийн болон бусад ижил төстэй тогтоомжуудыг хэрэглэхдээ олон улсын агаарын тээврийн ижил төрлийн үйлчилгээ явуулж буй өөрийн улсын эсхүл аливаа бусад агаарын тээвэрлэгчид, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчид олгосноос илүү давуу эрх олгохгүй.

#### **5А ДУГААР ЗҮЙЛ** **Шударга өрсөлдөөн**

1. Өрсөлдөөний шударга орчин бүрдүүлэх, Хэлэлцэн тохиролцогч Талуудын агаарын тээврийн байгууллагуудад тодтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээ эрхлэхэд нь өрсөлдөөний шударга, тэгш боломж олгох нь хамтарсан зорилт байна гэдгийг Хэлэлцэн тохиролцогч Талууд нотоллоо. Үүнээс үндэслэн Хэлэлцэн тохиролцогч Талууд энэ зорилтыг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.
2. Хэлэлцэн тохиролцогч тал Тал бүр энэхүү Хэлэлцээрт тусгагдсан эрхийг хэрэгжүүлэхээр өрсөлдөх боломжид сөргөөр нөлөөлөх алагчлах үзлийн бүх хэлбэр эсхүл шударга бус практикийг арилгах өөрийн хууль тогтоомжийн хүрээнд холбогдох бүхий л арга хэмжээг авна.
3. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн өрсөлдөөний тухай хууль тогтоомж, бодлого, практик, эсхүл түүнд өөрчлөлт оруулах тэдгээр нь энэхүү Хэлэлцээрийн дагуу үйлдэгдэж буй агаарын тээврийн үйлчилгээнд нөлөөлөхөөр бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа мэдэгдэж, Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой Нисэхийн удирдах байгууллагуудын хариуцлагыг тодорхойлно.
4. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрийн хууль тогтоомж, зохицуулалтаар зөвшөөрсөн хэмжээнд өөрсдийн өрсөлдөөний тухай хууль тогтоомж болон бодлогын хэрэглээний талаар зөвлөмж өгөх, байдлаар тус тусын агаарын тээврийн байгууллагад туслалцаа үзүүлнэ.
5. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал өөрийн томилсон агаарын тээврийн байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрээр зохицуулж буй агаарын тээврийн үйлчилгээг үзүүлэхэд шударга болон тэгш боломжид сөргөөр нөлөөлсөн эсхүл сөргөөр нөлөөлөхүйц ялгаварлан гадуурхал эсхүл шударга бус үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн гэж үзвэл хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа Зөвлөгөөн хийх талаар хүсэлт

хүргүүлж үл нийцэж буй асуудлын шалтгааны талаар мэдэгдэнэ. Хүсэлт хүргүүлснээс 30 хоногийн дотор Зөвлөгөөнийг хийнэ.

6. Хэлэлцэн тохиролцогчид Талууд зөвлөлдөөнөөр асуудлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал тус маргааны шийдвэрлэхээр энэхүү Хэлэлцээрийн 20 дугаар зүйлийн дагуу Маргаан шийдвэрлэх механизмыг ашиглаж болно.

## **6 ДУГААР ЗҮЙЛ**

### **Шууд дамжин өнгөрөх**

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын нутаг дэвсгэрээр нь шууд дамжин өнгөрч байгаа бөгөөд нисэх буудлын зориулалтын бүсээс гараагүй зорчигч, ачаа, тээшинд нисэхийн аюулгүй ажиллагаа, мансууруулах бодис, хууль бусаар хил нэвтрэхээс урьдчилсан сэргийлэх эсхүл онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд үзлэг шалгалт хийхгүй. Шууд дамжин өнгөрч байгаа ачаа, тээш нь гаалийн болон түүнтэй ижил төстэй бусад татвараас чөлөөлөгдөнө.

## **7 ДУГААР ЗҮЙЛ**

### **Үнэмлэх, гэрчилгээг хүлээн зөвшөөрөх**

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын дүрэм, журмын дагуу олгосон буюу хүчин төгөлдөр гэж үзсэн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, эрхийн гэрчилгээ, үнэмлэхийн хүчинтэй хугацаанд эдгээр гэрчилгээ болон үнэмлэх нь Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай тэнцүү эсхүл түүнээс дээш төвшнийг хангасан нөхцөлд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал тохиролцсон үйлчилгээ явуулахад хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрнө.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нутаг дэвсгэр дээгүүр нь эсхүл нутаг дэвсгэрт нь буух нислэгт зориулан Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас өөрийнх нь иргэдэд олгосон эрхийн гэрчилгээ, үнэмлэхийг хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй байна.
3. Хэлэлцэн тохиролцогч нэг Тал олгосон буюу хүчин төгөлдөр гэж үзсэн үнэмлэх гэрчилгээний нөхцөл, эрх нь Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандартаас зөрүүтэй байвал тэдгээр үл тохирлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдсэн эсэхээс үл хамааран Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал эдгээр үл тохирлыг хүлээн зөвшөөрөх боломжтой гэдэгт итгэлтэй байх зорилгоор энэхүү Хэлэлцээрийн (20) дугаар зүйлийн дагуу зөвлөгөөн хийх хүсэлтээ гаргаж болно.

## **8 ДУГААР ЗҮЙЛ**

### **Нисэхийн аюулгүй ажиллагаа**

1. Аль ч Хэлэлцэн тохиролцогч Тал, нисгэх баг, агаарын хөлөг, эсхүл тэдгээрийн аливаа үйл ажиллагаанд хамааруулан Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал баталсан аюулгүй ажиллагааны стандартын асуудлаар зөвлөгөөн хийх хүсэлтээ хэдийд ч гаргаж болно. Ийм зөвлөгөөнийг хүсэлт гаргасан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор хийнэ.
2. Ийм зөвлөгөөний дүнд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь дээрх салбаруудад аюулгүй ажиллагааны стандартыг наанадаж тухайн үед Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай тэнцүү тогтоон идэвхтэй мөрдөхгүй, зохион байгуулахгүй

байгааг Хэлэлцэн тохиролцогч нэг Тал тогтоовол, Хэлэлцэн тохиролцогч эхний Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа эдгээр дутагдлууд, наад захын стандартыг хангахад шаардлагатай гэж үзсэн алхмуудын талаар мэдэгдэх бөгөөд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал дутагдлаа засах зохих арга хэмжээ авна. Хэлэлцэн тохиролцогч нөгөө тал холбогдох хугацаанд буюу ямар ч тохиолдолд арван тав (15) хоног эсхүл өөрөөр тохирсон хугацаанд зохих арга хэмжээг аваагүй нь энэхүү Хэлэлцээрийн (4) дүгээр зүйлийг хэрэглэх үндэслэл болно.

3. Конвенцын (33) дугаар зүйлд заасан үүргийг үл харгалзан Хэлэлцэн тохиролцогч нэг Тал өөрөө эсхүл агаарын тээвэрлэгчийн нэрийн өмнөөс түрээсийн гэрээгээр, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү эсхүл нутаг дэвсгэрээс явуулж буй үйлчилгээндээ ашиглаж байгаа аливаа агаарын хөлөг нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх үед тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий төлөөлөгчид агаарын хөлгийн бүхээгт, агаарын хөлгийн эргэн тойронд, агаарын хөлгийн болон нисгэх багийн бичиг баримт аль аль нь хүчинтэй эсэх, агаарын хөлгийн тухайн үеийн гадаад байдал, түүний тоног төхөөрөмжийг (энэ зүйлд "газар дээрх үзлэг шалгалт" гэж нэрлэх) үзэж шалгаж болно гэж тохиролцсон бөгөөд үзлэг шалгалт нислэгийг саатуулах үндэслэл болохгүй байвал зохино.
4. Газар дээрх нэг эсхүл хэд хэдэн удаагийн ийм үзлэг шалгалтын үр дүнд:
  - (a) Агаарын хөлөг эсхүл түүний үйл ажиллагаа нь тухайн үед Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай нийцэхгүй байна гэж үзэх ноцтой үндэслэл илэрвэл; эсхүл
  - (b) Тухайн үед Конвенцын дагуу тогтоосон аюулгүй ажиллагааны стандартыг идэвхтэй мөрдөхгүй, зохицуулалтгүй байна гэж үзэх ноцтой үндэслэл илэрвэл, хяналт шалгалт явуулсан Хэлэлцэн тохиролцогч Тал, Конвенцын (33) дугаар зүйлийн зорилгод нийцүүлэн тухайн агаарын хөлөг түүнчлэн тухайн агаарын хөлгийн нисэх багт гэрчилгээ, үнэмлэх олгоход, эдгээрийг хүчин төгөлдөр гэж үзэхэд тавигдсан шаардлага эсхүл тухайн агаарын хөлгийг ашиглахад тавигдсан шаардлага нь Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандартыг хангаагүй эсхүл стандартаас илүүгүй байна гэсэн дүгнэлтээ чөлөөтэй гаргах эрхтэй.
5. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын агаарын тээвэрлэгчийн ашиглаж буй агаарын хөлөгт энэ зүйлийн (3) дахь заалтын дагуу газар дээрх үзлэг шалгалт хийх зорилгоор нэвтрүүлэхийг тухайн агаарын тээвэрлэгч татгалзсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал энэ зүйлийн (4) дэх заалтад дурдсан ноцтой үндэслэл үүссэн гэж үзэж, дээрх заалтад дурдсан дүгнэлт гаргах эрхтэй.
6. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нэг эсхүл хэд хэдэн удаагийн газар дээрх үзлэг шалгалтын үр дүн, газар дээрх үзлэг шалгалт хийлгэхээр нэвтрүүлэхийг зөвшөөрөөгүй, зөвлөлдөөн эсхүл бусад төрлийн харилцаа холбооны дүнд аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах зайлшгүй шаардлага үүсгэсэн гэж дүгнэвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчид олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсхүл өөрчлөх эрхээ хадгалж үлдэнэ.
7. Хэлэлцэн тохиролцогч нэг Талаас энэ зүйлийн (2) эсхүл (6) дугаар заалтын дагуу авч хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээ нь тухайн арга хэмжээг авах болсон үндэслэл арилснаар дуусгавар болно.

8. Бүгд Найрамдах Словени Улс нь Европын Холбооны өөр гишүүн улсаас зохицуулалтын хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулдаг агаарын тээвэрлэгчийг томилсон тохиолдолд тухайн агаарын тээвэрлэгчийг томилсон гишүүн улс болон Монгол Улс хоорондын Хэлэлцээрийн аюулгүй байдлын заалтад заасан эрхүүд нь Европын Холбооны нөгөө гишүүн улсын аюулгүй байдлын стандартыг батлах, хэрэгжүүлэх, баталгаажуулах болон тухайн агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох зэрэгт адил хамаарна.

## **9 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Нисэхийн аюулгүй байдал**

1. Олон улсын хуулиар хүлээсэн эрх үүргийнхээ дагуу, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хууль бус халдлагаас хамгаалахаар харилцан хүлээсэн үүрэг нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн болно гэдгийг Хэлэлцэн тохиролцогч Талууд дахин нотолж байна. Хэлэлцэн тохиролцогч Талууд 1963 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо байгуулсан “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон бусад тодорхой үйлдлийн тухай Конвенц”, 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гааг хотноо байгуулсан “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай Конвенц”, 1971 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Монреаль хотноо байгуулсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг таслан зогсоох тухай Конвенц”, түүнд нэмэлт болгон 1988 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Монреаль хотноо байгуулсан “Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүчирхийллийн хууль бус үйлдлийг таслан зогсоох тухай Протокол”, 1991 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Монреаль хотноо байгуулсан “Хуванцар тэсрэх бодисыг илрүүлэхийн тулд ялгах тэмдэглэгээ хийх тухай Конвенц” болон Хэлэлцэн тохиролцогч Талууд гишүүнээр нэгдэн орсон нисэхийн аюулгүй байдлын тухай аливаа бусад конвенц, протоколын заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.
2. Хэлэлцэн тохиролцогч Талууд хүсэлт хүлээн авмагц, иргэний агаарын тээврийн хөлгийг хууль бусаар булааж авах, иргэний агаарын хөлөг болон түүний зорчигч, нисгэх баг, нисэх буудал, агаарын навигацийн төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэл, иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аливаа бусад аюул заналаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л туслалцааг харилцан үзүүлнэ.
3. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөр хоорондын харилцаандаа Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон болон Конвенцод Хавсралт болгон оруулсан, Хэлэлцэн тохиролцогч Талууд хэрэгжүүлэх боломжтой аюулгүй байдлын эдгээр заалтууд, Стандартууд, Зөвлөмжүүдэд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна. Хэлэлцэн тохиролцогч Талуудын нутаг дэвсгэрт байгуулагдсан эсхүл бүртгэлтэй агаарын хөлөг ашиглагчид, эсхүл Бүгд Найрамдах Словени Улсын хувьд Европын Холбооны Гэрээний дагуу нутаг дэвсгэрт байгуулагдсан болон Европын Холбооны хууль дүрмийн дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй агаарын хөлөг ашиглагчид нь нутаг дэвсгэрт байрладаг нисэх буудал ашиглагчдыг нисэхийн аюулгүй байдлын эдгээр заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулахыг шаардана. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн үндэсний хууль дүрэм, дадал үйл ажиллагаа болон Хавсралтад заасан нисэхийн аюулгүй байдлын стандартууд хоорондын зөрүүг нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талдаа мэдэгдэнэ. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал ямарваа нэг зөрүүг хэлэлцэх зорилгоор хүссэн үедээ нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талтай шууд зөвлөлдөх хүсэлт гаргаж болно.

4. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр агаарын хөлөг ашиглагчдаас Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү нэвтрэн орох, түүнээс нисэн гарах, нутаг дэвсгэрт нь байх үед дээрх (3) дугаар заалтад дурдсан нисэхийн аюулгүй байдлын заалтууд, шаардлагуудыг судалсан байхыг шаардахыг зөвшөөрнө. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нутаг дэвсгэртээ агаарын хөлгийг хамгаалах, зорчигч, нисгэх баг, гар тээш, тээш, ачаа, агаарын хөлгийн нөөцийг агаарын хөлөгт зорчигчид авахаас өмнө, авах үед, эсхүл ачаа ачих үед шалгах зохих арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлнэ. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр тодорхой аюул заналын эсрэг аюулгүй байдлын зохистой тусгай арга хэмжээ авах тухай Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын аливаа хүсэлтийг нааштай хүлээн авна.
5. Иргэний агаарын хөлгийг хууль бусаар булаан авсан эсхүл булаан авах аюул занал учирсан, тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, зорчигчид, нисгэх баг, агаарын хөлөг, нисэх буудал эсхүл агаарын навигацийн төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн бусад хууль бус үйлдэл гарсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Талууд дээрх үйлдэл эсхүл аюул заналыг шуурхай, аюулгүй байдлаар таслан зогсооход чиглэсэн холбоо барих болон бусад зүй зохистой арга хэмжээ авч харилцан тусалж ажиллана.

## **10 ДУГААР ЗҮЙЛ**

### **Ашиглалтын хураамж**

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч, нисэх буудал, агаарын навигаци, бусад тоног төхөөрөмж ашигласны төлөө ногдуулж буй хураамж нь аливаа бусад адил ангиллын, олон улсын агаарын тээврийн ижил үйлчилгээ эрхэлж буй агаарын хөлгийн төлж буй хураамжаас ихгүй байна.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр хураамж ногдуулах эрх бүхий өөрийн байгууллагууд, хураамж ногдуулж буй байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, тэдний тоног төхөөрөмжийг ашиглагч агаарын тээвэрлэгч, боломжтой гэж үзвэл агаарын тээвэрлэгчийн төлөөлөгч байгууллагын хооронд ашиглалтын хураамжийн асуудлаар зөвлөлдөөн хийхийг дэмжинэ.
3. Ашиглалтын ийм хураамжид өөрчлөлт оруулах аливаа саналын тухай үндэслэлтэй мэдэгдлийг агаарын тээвэрлэгчид өөрчлөлт оруулахаасаа өмнө байр сууриа илэрхийлэх боломж олгох үүднээс урьдчилан өгнө. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр хураамж ногдуулах эрх бүхий өөрийн байгууллага, агаарын тээвэрлэгчид хураамжийн талаар зохих мэдээлэл солилцож байхыг цаашид ч дэмжинэ.

## **11 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Гаалийн татвар болон бусад хураамжууд**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийг импортын хязгаарлалтууд, гаалийн татвар, шууд бус татвар, үзлэгийн хураамж, агаарын хөлөг, шатахуун, тослох материал, техник хангалтын жижиг зүйлс, хөдөлгүүрийг оролцуулсан сэлбэг хэрэгсэл, агаарын хөлгийн байнгын тоног төхөөрөмж, агаарын хөлгийн нөөц хүнсний зүйлс (үүнд хүнс, ундаа, ликёр, тамхи, уушны зүйлс болон нислэгийн хугацаанд зорчигчдод хязгаартай тоогоор худалдах зориулалттай бусад бүтээгдэхүүн) болон зөвхөн Хэлэлцэн тохиролцогч тэр Талын томилсон, тохиролцсон үйлчилгээ эрхэлж буй агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн нислэгт, агаарын хөлөгт үйлчилгээ хийхэд зориулсан бусад зүйлс,

түүнчлэн хэвлэмэл тасалбарын нөөц, ачааны дагалдах хуудас, агаарын тээвэрлэгчийн лого тэмдгийг дээр нь хэвлэсэн, аливаа хэвлэмэл материалууд, томилогдсон агаарын тээвэрлэгч сурталчилгааны зориулалтаар үнэгүй тараах ердийн хэвлэмэл материалуудыг үндэсний болон орон нутгийн татвар хураамжаас чөлөөлнө.

2. Энэ зүйлийн (1) дэх заалтад дурдсан зүйлүүд зөвхөн дараах нөхцөлд татварын чөлөөлөлт эдэлнэ:
  - (a) Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилсон агаарын тээвэрлэгч өөрөө эсхүл түүний нэрийн өмнөөс оруулж ирсэн бол;
  - (b) Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нисэн ирэхэд байсан, нисэн явтал агаарын хөлгийн бүхээгт хадгалагдаж байсан бол;
  - (c) Тохиролцсон үйлчилгээ явуулахад хэрэглэх зорилгоор, Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт авсан бол; татвараас чөлөөлж байгаа тэр Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт эдгээр зүйлс бүгд эсхүл зарим хэсэг нь хэрэглэгдсэн эсхүл борлуулагдсан эсэхээс үл хамааран, дурдсан Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт эдгээр зүйлсийн эзэмшил бусдад шилжээгүй бол.
3. Хэлэлцэн тохиролцогч аль ч Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт ердийн журмаар байх бүхээгийн байнгын тоноглол, хөлгийн бүхээг дэх эд материал, хангамжийн зүйл, бүхээгийн нөөцийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зөвхөн энэ нутаг дэвсгэрийн гаалийн байгууллагын зөвшөөрлөөр хөлгийн бүхээгээс буулгаж болно. Ийм тохиолдолд эдгээр зүйлсийг гаалийн дүрэм журмын дагуу буцааж экспортлох, эсхүл өөр замаар ашиглаж дуусгах тэр цагийг хүртэл дурдсан эрх баригчдын хяналтын дор хадгална.
4. Хэлэлцэн тохиролцогч аль ч Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас ногдуулдаг татвар хураамжаас чөлөөлөгдөх эрхийг мөн адил эдэлдэг өөр агаарын тээвэрлэгч энэ зүйлийн (1) дүгээрт заасан зүйлсийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зээлээр эсхүл шилжүүлэн авахаар тохиролцсон нөхцөлд техникийн жижиг зүйлс, хөдөлгүүрийг оролцуулан сэлбэг хэрэгсэл, бүхээгийн байнгын тоноглол энэ зүйлийн заалтын дагуу татвар хураамжаас чөлөөлөгдөнө. Агаарын тээвэрлэгч тийм зээл, шилжүүлгийг гаалийн холбогдох байгууллагад мэдэгдсэн байна.
5. Бүгд Найрамдах Словени Улсын нутаг дэвсгэр дэх цэгүүд болон өөр Европын Холбооны гишүүн улсын нутаг дэвсгэр дэх цэгүүд хооронд үйлчилгээ үзүүлж буй Монгол Улсын томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийг тухайн нутаг дэвсгэрт сумласан шатахууны татвар, хураамж, төлбөрийг ялгаварлан гадуурхахгүйгээр Словенийн талаас ногдуулахад энэхүү Хэлэлцээр саад учруулахгүй.
6. Монгол Улсын хууль дүрэмд нийцүүлэн харилцан үйлчлэх үндсэн дээр, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цэгүүд хооронд үйлчилгээ үзүүлж буй Бүгд Найрамдах Словени Улсын томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийг тухайн нутаг

дэвсгэрт сумласан шатахууны татвар, хураамж, төлбөрийг ялгаварлан гадуурхахгүйгээр Монголын талаас ногдуулахад энэхүү Хэлэлцээр саад учруулахгүй.

## **12 ДУГААР ЗҮЙЛ**

### **Багтаамж**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын томилогдсон агаарын тээвэрлэгч тохиролцсон үйлчилгээг тогтоосон маршрутад энэхүү Хэлэлцээрийн (2) дугаар зүйлийн дагуу явуулахад шударга, эрх тэгш боломжоор хангаж, Хэлэлцэн тохиролцогч Талууд харилцан ашигтай байхын тулд нийт багтаамжийг тэнцүү хуваах зарчмыг баримтална.
2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын томилогдсон агаарын тээвэрлэгчийн тохиролцсон үйлчилгээний нийт багтаамжийг үйл ажиллагаа эхлэхээс өмнө, цаашдын нислэгийн хөдөлгөөний тооцоот шаардлагын дагуу Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэний нисэхийн удирдах байгууллагууд харилцан тохиролцоно.
3. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр, тэдгээрийн томилогдсон агаарын тээвэрлэгч нөгөө Хэлэлцэн тохиролцогч Тал, түүний томилогдсон агаарын тээвэрлэгчийн үзүүлдэг үйлчилгээнд хэт нөлөөлөлгүй, түүний ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

## **13 ДУГААР ЗҮЙЛ**

### **Тариф**

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү болон нутаг дэвсгэрээс тээвэрлэлт хийхдээ мөрдөх тарифыг үйл ажиллагааны зардал, боломжит ашиг, үйлчилгээний шинж чанар, хэрэглэгчийн ашиг сонирхол, тогтоосон маршрутын хэсэгт үйлчилгээ явуулж буй бусад агаарын тээврийн байгууллагын тариф болон зах зээл дэх арилжааны шийдэл зэрэг нөлөөлөх бүх хүчин зүйлийг харгалзан зохистой түвшинд тогтооно.
2. Хэлэлцэн тохиролцогч Талууд нэг Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн санал болгож буй тариф нь хэт ялгаварласан эсхүл ерөнхий чиг хандлагаас хэт өндөр, шууд болон шууд бус татаасны нөлөөгөөр доогуур тогтоосон зохиомол тарифт онцгой анхаарал хандуулна.
3. Тарифыг тогтоохдоо аль болох Хэлэлцэн тохиролцогч Талуудын Засгийн газруудын шаардлагатай хэлэлцээний дараа Хэлэлцэн тохиролцогч Талуудын харгалзах томилогдсон агаарын тээвэрлэгчийн харилцан зөвшилцөл, мөн хэрэв хамааралтай бол бусад агаарын тээвэрлэгчтэй зөвлөлдөж тогтооно. Ингэхдээ харгалзах олон улсын тариф зохицуулах механизмыг баримтална. Дээрх байдлаар тарифын хоёр эсхүл олон талт тохиролцоонд хүрч чадаагүй томилогдсон агаарын тээвэрлэгч тус бүр бие дааж тариф тогтоож болно.
4. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн өөрийн нутаг дэвсгэрт эхлэл, төгсгөлтэй тээвэрлэлтэд санал болгож буй тарифын тухай мэдэгдэл эсхүл бүртгэлийг шаардаж болно. Ийм мэдэгдэл эсхүл бүртгэлийг тариф танилцуулахаас жар (60)-аас илүүгүй хоногийн өмнө шаардаж болно. Онцгой тохиолдолд уг хугацааг богиносгож болно.



5. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэрээс эхлэлтэй Хэлэлцэн тохиролцогч Талуудын нутаг дэвсгэр хоорондын тээвэрлэлтийн нэг талын эсхүл хоёр талын аяллын тарифыг батлах эсхүл эс батлах эрхтэй.
6. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал энэ зүйлийн (5) дугаар заалтын үр дүнгийн дараа тарифын баталгаажуулалтыг тарифыг тогтоож буй агаарын тээвэрлэгч нэн даруй мэдэгдэнэ. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал (томилогдсон агаарын тээвэрлэгч) тарифыг батлахаас татгалзсан тухай бичгээр мэдэгдлээ хүргүүлсэн өдрөөс гуч (30) хоногийн дотор ирүүлээгүй тохиолдолд, тухайн тарифыг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Дөрөвдүгээр заалтын дагуу тарифыг баталгаажуулах хугацааг богиносгосон тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Талууд татгалзах хариуг мэдэгдэх хугацааг харилцан тохиролцсон гэж ойлгоно.
7. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр энэхүү Хэлэлцээрээр зохицуулагдаж буй үйлчилгээг үзүүлэгч Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн агаарын тээвэрлэгчийн тарифтай холбоотой асуудлаар мөн харгалзах тариф нь хүлээн зөвшөөрөөгүй эсхүл эргэлзээтэй тухай мэдэгдэлтэй холбоотойгоор зөвлөгөөн хийх хүсэлт гаргаж болно. Ийм зөвлөгөөнийг хүсэлт хүлээж авсан өдрөөс гуч (30)-аас доошгүй хоногийн дотор хийнэ. Хэлэлцэн тохиролцогч Талууд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийн нууцлалыг харилцан хадгална. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч Талууд тохиролцоонд хүрвэл, Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр уг тохиролцоог хүчин төгөлдөр болгох хүчин чармайлт гаргана. Хэрэв тохиролцоонд хүрээгүй тохиолдолд тээвэрлэлт нутаг дэвсгэрээс нь эхэлж буй Хэлэлцэн тохиролцогч Талын шийдвэр давамгайлна.
8. Энэ зүйлийн заалтуудын дагуу тогтоогдсон тариф нь харгалзах агаарын тээвэрлэгч уг тарифыг цуцлах эсхүл шинэ тариф батлах хүртэл хүчин төгөлдөр байна.

#### **14 ДҮГЭЭР ЗҮЙЛ** **Орлого гуйвуулах**

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын томилсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт борлуулалт хийж олсон орлогын тухайн орон нутаг дэвсгэрт гаргасан зарлагаасаа давсан хэсгийг чөлөөтэй хөрвөх валютаар хөрвүүлэх, өөрийн нутаг дэвсгэр рүү гуйвуулах эрхтэй. Валют хөрвүүлэх, гуйвуулга хийхдээ тухайн гуйвуулгад мөрдөж болох, гуйвуулга хийсэн өдрийн валют солилцооны зах зээлийн ханшаар, хязгаарлалтгүй хийнэ. Гадаад валют солих зах зээлийн ханшны систем тогтоогдоогүй нөхцөлд хөрвүүлэлт, гуйвуулга хийсэн өдрийн валют солилцооны албан ханшны үндсэн дээр хязгаарлалтгүй хийнэ. Бодит гуйвуулга саадгүй хийгдэх бөгөөд ийм гуйвуулга хийхэд банкны үйлчилгээний ердийн хураамжаас өөр хураамж төлөхгүй.
2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд хийгдэх төлбөрүүдийг тусгай хэлэлцээрээр зохицуулдаг бол ийм хэлэлцээрийг мөрдөнө.

#### **15 ДУГААР ЗҮЙЛ** **Арилжааны үйл ажиллагаа**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгч олон улсын агаарын тээврийн үйлчилгээ, түүнтэй адилтгах бүтээгдэхүүнийг түүний нутаг дэвсгэрт шууд эсхүл тухайн томилогдсон агаарын тээврийн байгууллагын сонгосон төлөөлөгч болон дундын зуучлагчаар дамжуулан

борлуулах, зах зээлд гаргах, үүнд онлайн, оффлайн оффис байгуулах зэрэг зөвшөөрлийг олгоно.

2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн томилогдсон агаарын тээвэрлэгчийн менежер, техник, үйл ажиллагааны болон бусад олон улсын агаарын тээврийн үйлчилгээ явуулахад шаардлагатай мэргэжилтэн, ажилтан албан хаагчаа Хэлэлцэн тохиролцогч тухайн улсын хууль тогтоомжийн дагуу, түүний нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, оршин суулгах, түүнд ажил олгох эрхтэй.
3. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр шатахуун худалдан авах болон бусад үйл ажиллагааны зардлыг дотоодын мөнгөн тэмдэгтээр эсхүл өөрийн үзэмжээр дотоодын мөнгөн тэмдэгтийн харгалзах дүрэм журмын дагуу чөлөөтэй хөрвөх валютаар төлөх эрхтэй.

## **16 ДУГААР ЗҮЙЛ**

### **Аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт**

1. Энэхүү Хэлэлцээрийн Хавсралт дахь тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээг үзүүлсэн эсхүл үзүүлээгүй тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Тал бүрээс томилогдсон агаарын тээвэрлэгч суудал хадгалах, аяллын дугаар хамтран ашиглах зэрэг зохицуулалтыг хийх бөгөөд ингэхдээ дор дурдсан талуудтай хамтран ажиллана. Тэдгээр нь:
  - (a) Нэг талаас томилогдсон агаарын тээвэрлэгч,
  - (b) Хоёр талаас томилогдсон агаарын тээвэрлэгч,
  - (c) Гуравдагч улсын агаарын тээвэрлэгч,

Дээр дурдсан зохицуулалт нь зөвхөн доорх нөхцөлд хэрэгжинэ. Үүнд:

- (i) Ийм зохицуулалтад орж байгаа бүх агаарын тээвэрлэгчид тухайн маршрут эсхүл хэсэгт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх;
  - (ii) Борлуулагдсан тасалбар бүрийн хувьд агаарын тээвэрлэгч нь худалдан авагчид аль агаарын тээвэрлэгч аяллын ямар хэсэгт нислэг үйлдэж байгааг тодорхой мэдээлнэ.
2. Томилогдсон агаарын тээвэрлэгч нь аяллын дугаар хамтран ашиглах тохиролцсон үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд үйл ажиллагаа явуулсан багтаамжийг тус агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Талын эдлэх ёстой багтаамжийн эрхээс хасаж тооцно. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчийн гүйцэтгэж буй нислэгийг борлуулсан томилогдсон агаарын тээвэрлэгчийн багтаамжийг Хэлэлцэн тохиролцогч Талын томилсон, тус нислэгийг борлуулсан агаарын тээвэрлэгчийн багтаамжийн эрхээс хасаж тооцохгүй.

## **17 ДУГААР ЗҮЙЛ**

### **Цагийн хуваарь**

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч товлож буй үйлчилгээнийхээ цагийн хуваарийг нислэгийн давтамж, агаарын хөлгийн маяг, хийц, нислэг үргэлжлэх хугацаа, олон нийтэд борлуулах боломжит суудлын тоо, цагийн хуваарийг мөрдөх мөчлөгийн тодорхойлолтын хамт үйлчилгээгээ эхлэхээс наанадаж гуч (30) хоногийн өмнө Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нисэхийн

удирдах байгууллагад танилцуулна. Цагийн хуваарьт аливаа өөрчлөлт оруулах бүр мөн ийм ажиллагаа хийгдэнэ.

2. Томилогдсон агаарын тээвэрлэгч цагийн хуваарьт тусгасан тэдгээр нислэгүүдээс гадна, нэмэлт нислэг үйлдэхийг хүсвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагаас зөвшөөрөл хүснэ. Ийм хүсэлтээ ердийн журмаар нислэг үйлдэхээс гурав (3)-аас доошгүй ажлын өдрийн өмнө гаргана.

### **18 ДУГААР ЗҮЙЛ**

#### **Статистик мэдээлэл**

Хэлэлцэн тохиролцогч аль ч Талын иргэний нисэхийн удирдах байгууллага, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэний нисэхийн удирдах байгууллагын хүсэлтийн дагуу томилогдсон агаарын тээврийн байгууллагуудын эсхүл Хэлэлцэн тохиролцогч эхний Талын томилогдсон аливаа агаарын тээврийн байгууллагын энэхүү Хэлэлцээрийн (2) дугаар зүйлийн дагуу тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээний багтаамжийг судлахад нь шаардагдаж болох үечилсэн болон бусад статистикийн мэдээллээр хангана. Ийм төрлийн мэдээлэл нь томилогдсон агаарын тээврийн байгууллагууд тохиролцсон үйлчилгээний дагуу хийсэн тээвэрлэлтийн хэмжээ болон тээвэрлэлтийн эхлэл төгсгөлийг тодорхойлоход шаардагдах бүх мэдээллийг агуулсан байна.

### **19 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **Зөвлөгөөн**

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хамаарах бүх асуудлаар нягт хамтын ажиллагааг хангах зорилгоор уулзалт хэлэлцээр хийх эсхүл захидал бичих замаар харилцана.
2. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал энэхүү Хэлэлцээртэй хамаарах аливаа бэрхшээлтэй асуудлаар зөвлөлдөх хүсэлтээ хэдийд ч гаргаж болно. Ийм зөвлөлдөөнийг Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрөөр тохиролцоогүй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хүсэлт илгээсэн өдрөөс хойших жар (60) хоногийн хугацааны дотор эхэлнэ.

### **20 ДУГААР ЗҮЙЛ**

#### **Маргаан шийдвэрлэх**

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон маргаан үүсвэл Хэлэлцэн тохиролцогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд уг маргааныг нэн түрүүнд хэлэлцээрийн замаар шийдэхийг эрмэлзэнэ.
2. Нисэхийн удирдах байгууллагууд зөвшилцөлд хүрч чадаагүй бол маргааныг Хэлэлцэн тохиролцогч Талууд хэлэлцэн шийднэ.
3. Хэлэлцэн тохиролцогч Талууд маргааныг хэлэлцэн шийдэж чадаагүй бол Хэлэлцэн тохиролцогч Талууд хүлээн зөвшөөрөх зөвлөмж санал эсхүл шийдвэр гаргах, талууд харилцан зөвшөөрсөн тийм хувь хүн эсхүл байгууллагад хандаж болно. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүсэлтээр уг маргааныг шийдүүлэхээр гурван арбитрчаас бүрдэх арбитрын шүүхэд шилжүүлнэ.
4. Гурван арбитрчийн ийм шүүх нь дараах байдлаар байгуулагдсан байна:

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр шүүхийн нэг гишүүнийг томилох ба энэ хоёр гишүүн тохиролцон шүүхийн даргаар ажиллах гуравдагч орны иргэнийг томилно. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал маргааныг гурвалсан арбитрын шүүхээр шийдүүлэх хүсэлтээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа мэдэгдсэнээс хойш шүүхийн гишүүдийг жар (60) хоногийн дотор, шүүхийн даргыг ер (90) хоногийн дотор томилно.

5. Дээрх (4) дүгээр заалтад тодорхойлсон хугацааг ашиглаагүй, аливаа бусад хамаарах зохицуулалт хийгдээгүй бол Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал шаардлагатай томилолт хийж өгөх хүсэлтээ Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгчид хандан гаргаж болно. Ерөнхийлөгч Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын үндэстэн эсхүл ямар нэг өөр шалтгаанаар энэ үүргийг гүйцэтгэх боломжгүй бол түүний дараа орох ахлах албан тушаалтан шаардлагатай томилгоог хийнэ.
6. Гурвалсан арбитрын шүүх шийдвэрээ олонхын саналаар гаргана. Ийм шийдвэрүүдийг Хэлэлцэн тохиролцогч Талууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр шүүх дэх өөрийн гишүүний болон арбитрын ажиллагаанд оролцсон өөрийн төлөөлөгчийн зардлыг хариуцах бөгөөд шүүхийн даргын болон аливаа бусад зардлыг Хэлэлцэн тохиролцогч Талууд тэнцүү хуваан төлнө. Бусад бүх асуудлаар гурвалсан арбитрын шүүх ажиллагааны дэгээ өөрөө тодорхойлно.

## **21 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах**

1. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийн аль нэг заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзвэл (18) дугаар зүйлд заасны дагуу уг нэмэлт, өөрчлөлтийг тохиролцоно. Хэлэлцэн тохиролцогч Талууд дипломат шугамаар бие биедээ олон улсын Хэлэлцээр байгуулах, хүчин төгөлдөр болохтой холбоотой дотоодын журмаа гүйцээсэн тухай мэдэгдсэнээр энэхүү нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.
2. Дээрх (1) дүгээр заалтыг үл харгалзан энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд хооронд шууд тохиролцож болно. Ийм нэмэлт өөрчлөлтийг дипломат шугамаар баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
3. Агаарын тээврийн тухай олон талт конвенц Хэлэлцэн тохиролцогч Талуудын хувьд хүчин төгөлдөр болбол энэхүү Хэлэлцээрт зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

## **22 ДУГААР ЗҮЙЛ**

### **Олон төрөлт тээврийн үйлчилгээ**

Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүрээс томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эсхүл гуравдагч орны нутаг дэвсгэрт байрлах аль ч цэгээс болон цэг рүү зорчигч, ачаа агаараар болон газраар тээвэрлэхтэй холбогдуулан газрын тээвэр ашиглаж болно. Томилогдсон агаарын тээвэрлэгч газрын тээвэрээ Хэлэлцэн тохиролцогч холбогдох Талын хүчин төгөлдөр хууль, тогтоомжийн хүрээнд, нутаг дэвсгэрт нь өөрөө хийх эсхүл газрын тээврийн бусад компанитай байгуулсан аяллын дугаар хуваан ашиглах зэрэг зохицуулалтаар хийлгэхээ сонгож

болно. Олон төрөлт тээврийн үйлчилгээ нь олон тээвэрлэгчээр дамжсан, агаарын болон газрын тээврийг нэгтгэсэн, нэг үнэтэй байж болох бөгөөд зорчигчид болон ачаа илгээгч нарт ийм тээврийн талаар мэдээлэл өгсөн байна.

### **23 ДУГААР ЗҮЙЛ**

#### **Олон талт хэлэлцээрүүд**

Олон улсын агаарын тээвэрт хамаарах, Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын хоорондын харилцаанд нөлөөлөх олон талт конвенц хүчин төгөлдөр болсон нөхцөлд олон талт конвенцын заалтуудад нийцүүлэн Хэлэлцэн тохиролцогч хоёр Тал хүлээн зөвшөөрсөн тийм заалтуудыг энэхүү Хэлэлцээрт нэмж оруулна.

### **24 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **Олон улсын иргэний нисэхийн байгууллагад бүртгүүлэх**

Энэхүү Хэлэлцээр болон түүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад бүртгүүлнэ.

### **25 ДУГААР ЗҮЙЛ**

#### **Хэлэлцээр цуцлах**

1. Аль нэг Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлээ, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа бичгээр, дипломат шугамаар хэдийд ч өгч болно. Ийм мэдэгдлийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад нэгэн зэрэг өгнө. Хэлэлцэн тохиролцогч Талууд тохиролцоонд хүрч Хэлэлцээр цуцлах мэдэгдлийг нэг жилийн хугацаа дуусахаас өмнө буцаан татаж аваагүй тохиолдолд, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал Хэлэлцээр цуцлах тухай мэдэгдэл илгээснээс хойш арван хоёр (12) сарын дараа Хэлэлцээр цуцлагдана.
2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал мэдэгдлийг хүлээн авсан тухайгаа нотлоогүй тохиолдолд Олон улсын иргэний нисэхийн байгууллагад уг мэдэгдлийг илгээснээс хойш арван дөрөв (14) хоногийн дараа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал мэдэгдэл хүлээн авсанд тооцно.

### **26 ДУГААР ЗҮЙЛ**

#### **Хүчин төгөлдөр болох**

Энэхүү Хэлэлцээрийг Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн хууль тогтоомжийн дагуу батлах бөгөөд дипломат нотоор харилцан мэдэгдэх замаар баталгаажуулна. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болоход шаардлагатай дотоодын журмаа гүйцэтгэсэн тухай сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсны дараа энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийг \_\_\_\_\_ хотод \_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр англи, монгол, словени хэл дээр тус бүр хоёр хувь байгуулсан бөгөөд бүх бичвэр ижил тэгш эрхтэй. Хэлэлцээрийг тайлбарлахад ямар нэгэн зөрүү гарвал англи хэл дээрх эхийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ**

**Маршрутын хуваарь**

**1 дүгээр хэсэг**

Монгол Улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаа явуулах маршрут:

Монгол Улс дахь цэгүүд	Завсрын цэгүүд	Бүгд Найрамдах Словени Улс дахь цэгүүд	Хилийн чанад дахь цэгүүд

**ТАЙЛБАР:**

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын томилогдсон агаарын тээвэрлэгч аль нэг эсхүл бүх нислэгтээ дээр тогтоосон маршрутын дагуух цэгүүдийг алгасаж болох бөгөөд эдгээр маршрутаар үйлдэхээр тохиролцсон үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс эхлэлтэй нөхцөлд завсрын цэгүүд, Бүгд Найрамдах Словени Улс дахь цэгүүд болон хилийн чанад дахь цэгүүдэд аливаа үйлчилгээг үзүүлж болно.
2. Агаарын тээврийн тавдугаар эрхийг хэрэгжүүлэх асуудлыг Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэний нисэхийн удирдах байгууллагууд харилцан тохиролцоно.

**2 дугаар хэсэг**

Бүгд Найрамдах Словени Улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаа явуулах маршрут:

